



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/58

Бор-Өндөр

Ой хээрийн түймрээс урьдчилан  
сэргийлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн "Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/191 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. сумын хэмжээнд "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх" ажлыг 2024 оны 03 дугаар сараас эхлэн 06 дугаар сарын хооронд, 2024 оны 09 дүгээр сараас эхлэн 11 дүгээр сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Галбадрах

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга

Б.Баярбаясгалан

Байгаль хамгаалагч

Гишүүд:

Б.Мөнх-Оргил

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Н.Отгонбилэг

Өлгий 6 дугаар багийн Засаг дарга

Ш.Цэрэндолгор

Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Р.Мөнхдорж

Гал түймрийн хяналтын Улсын байцаагч,  
ахмад

2. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлан мэдээг 2024 оны 09 дүгээр сарын 10, 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хэнтий аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэн ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г. А. ДЪЯАБИЛЭГТ